



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Очир Илч ХХК-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/01/СТА-ОНӨААН**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p> <p>Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	9
3.8 Аудитын гол асуудал	9
Анхан шатын баримтгүй гүйлгээ хийсэн, зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн байна.	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
4. Аудитын илрүүлэлт.....	9
4.1 Залруулсан алдаа	10
4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.	10
4.3 Албан шаардлага	10
4.4 Зөвлөмж	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ОЧИР ИЛЧ ХХК-ЫН
ЗАХИРАЛ Т.АЛИМАА-Д

2022.02.25 № 1362/170
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Очир илч ХХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Очир илч ХХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,043.9	2,575.1
1.1.2	Дансны авлага	39,888.3	32,930.6
1.1.6	Бараа материал	2,807.3	2,807.3
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	44,739.5	38,313.0
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,925,871.0	1,810,896.7
1.2.2	Биет бус хөрөнгө	57,077.5	57,077.5
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,982,948.5	1,867,974.2
1.3	Нийт хөрөнгийн дүн	2,027,688.0	1,906,287.2
1.1.3	Татварын өр	17,687.7	16,278.5
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	24,810.0	33,810.0
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	154,179.9	154,179.9
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	196,677.6	204,268.4
2.2	Өр төлбөрийн нийт дүн	196,677.6	204,268.4
2.3	Өмч	1,763,569.8	1,763,569.8
2.3.1	-төрийн	1,763,569.8	1,763,569.8
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	986,903.9	986,903.9
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-919,463.3	-1,048,454.9
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,831,010.4	1,702,018.8
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,027,688.0	1,906,287.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	181,682.4	163,053.0
3	Нийт ашиг (алдагдал)	181,682.4	163,053.0
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.0	275,723.3
10	Ерөнхий ба удирдлагын зардал	345,352.8	1,186.1
12	Бусад зардал	0.0	15,135.2
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-162,123.7	-128,991.6
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-162,123.7	-128,991.6

22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-162,123.7	-128,991.6
24	Орлогын нийт дүн	-162,123.7	-128,991.6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,763,569.8	986,903.9	-776,115.6	1,974,358.1
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	18,776.0	18,776.0
2	Залруулсан үлдэгдэл	1,763,569.8	986,903.9	-757,339.6	1,993,134.1
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	-162,123.7	-162,123.7
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,763,569.8	986,903.9	-919,463.3	1,831,010.4
2	Залруулсан үлдэгдэл	1,763,569.8	986,903.9	-919,463.3	1,831,010.4
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	-128,991.6	-128,991.6
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,763,569.8	986,903.9	-1,048,454.9	1,702,018.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн	199,369.0	179,358.3
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	199,369.0	179,358.3
1.2	Мөнгөн зарлагын дүн	197,395.7	157,872.5
1.2.1	Ажиллагчдад төлсөн	72,815.9	72,150.6
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,470.6	21,630.2
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,705.2	13,782.6
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	73,748.7	13,107.4
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,303.3	1,000.0

1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,769.9	25,385.9
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,582.1	10,815.8
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,973.3	21,485.8
2.2	Мөнгөн зарлагын дүн	1,280.0	1,954.6
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,280.0	1,950.0
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.0	4.6
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,280.0	-1,954.6
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	19,000.0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.0	19,000.0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	-19,000.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	693.3	531.2
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,350.6	2,043.9
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,043.9	2,575.1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Очир Илч ХХК -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Б.Дагвасүрэн нар хэрэгжүүлсэн.

Очир Илч ХХК -ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 11-ний өдрийн 3/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Очир Илч ХХК нь хэрэглэгчдэд өнөөгийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн тав тухтай эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд хэрэгцээт бараа бүтээгдэхүүн үйлчилгээг нэг дороос цогц хүртэх боломжыг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Очир Илч ХХК -ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 172,714.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,590.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,943.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 290,977.1 мянган төгрөгний нийт зардлаас 1.5 хувиар тооцож 4,364.6 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	44,739.5	38,313.0	6,426.5
5	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,982,948.5	1,867,974.2	114,974.3
3	Богино хугацаат өр төлбөрийн дүн	196,677.6	204,268.4	-7,590.8
4	Эздийн өмчийн дүн	1,831,010.4	1,702,018.8	128,991.6
5	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,027,688.0	1,906,287.2	121,400.8

Эргэлтийн хөрөнгийн дүн 6,426.5 мянган төгрөгөөр буурсан нь авлагын бууралттай холбоотой байна.

Эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл 114,974.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,590.8 мянган төгрөгөөр өссөн нь өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотой үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 128,991.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн ашиг буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 2,043.9 мянган төгрөг байсан бөгөөд гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого 179,358.3 мянган төгрөгийн орлого олж урсгал үйл ажиллагаанд 157,872.5 мянган төгрөгийг, хөрөнгө оруулалтын мөнгөн зардалд 1,954.6 мянган төгрөгийг, санхүүгийн үйл ажиллагаанд 19,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 2575.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Анхан шатын баримтгүй гүйлгээ хийсэн, зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 59 мэдээлэл, хугацаа хоцроосон 67 мэдээлэл байна. Аудитын явцад шилэн дансны мэдээллийг засаж оруулсан тул хугацаа хоцроосон мэдээллээр бүртгэгдсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдэлт

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,090.0 мянган төгрөгийн 4 алдаа илрүүлсэнээс 1,775.0 мянган төгрөгийн актыг аудитын явцад барагдуулж залруулж 3,315.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

4.2 Төлбөрийн акт

- 1,775.0 мянган төгрөгийн баримтгүй гүйлгээ хийсэнд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Зөвшөөрөлгүй 1,815.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхэд 1,500.0 мянган төгрөг зарцуулсан нь Засгийн газрын 43-р тогтоолыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.

Дээрх акт албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1.	Очир Илч ХХК	3	5,090.0			1	1,775.0	2	3,315.0		
	Дүн	3	5,090.0			1	1,775.0	2	3,315.0		